



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/139

Алтанбулаг

**Хугацаат цэргийн албаны ээлжит
татлага зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.1, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам”-ын 2.2.2, 2021 оны мн/132 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны н/220 дугаар тушаал, Батлан хамгаалах сайд, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний ажил, үйлчилгээний 2 заалт, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/390 тоот захирамж, 2022 онд сумдын Засаг дарга аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 17.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хугацаат цэргийн албаны 2022 оны хоёрдугаар ээлжийн татлагыг 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсугай.
2. Хугацаат цэргийн албаны 2022 оны хоёрдугаар ээлжийн татлагад 1996-2004 онд төрсөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.
3. Цэрэг татлагын анкетыг 18-26 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн тус бүрд бүртгэн шивж, “Байгууллагын баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалт”-ын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Зориг), 2 дугаар багийн Засаг дарга (Н.Мөнхзул), 3 дугаар багийн Засаг дарга (Г.Мөнхболд) нарт даалгасугай.
4. Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа иргэдэд Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн үндсэн Цусны ерөнхий, шээсний ерөнхий, биохимийн (сахар, АСАТ, АЛАТ, креатинин, мочевин) элэгний В,С вирус илрүүлэх, ДОХ, тэмбүүгийн, түргэвчилсэн шинжилгээг бүрэн хийлгэж, анкетад нь

хавсаргах, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг ирүүлэхийг Эрүүл мэндийн төвийн дарга, эмчлэгч эмч (У.Энхбямба)-д, сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Янжиндулам)-д тус тус үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн үзлэгт орж байгаа хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, татагдагчдад Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/30, А/33 дугаар тушаалын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, голомтын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга, эмчлэгч эмч (У.Энхбямба)-д үүрэг болгосугай.

6. Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах хугацаанд буюу 2022 оны 10 дугаар сарын 07-25-ны өдрийг дуустал сумын хэмжэээнд цэргийн насны залуучуудын шилжилт хөдөлгөөнийг түр зогсоож, хялбаршуулсан журмаар хил нэвтрэх нэг удаагийн эрхийн үнэмлэх олгохгүй байхыг Улсын бүртгэгч (Ж.Нарангэрэл)-д даалгасугай.

7. Хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучууд (18-25) нэг бүрд зарлан дуудах хуудас гардуулан өгч, цэрэг татлагын байранд заасан хугацаа тогтоосон цагт бэлэн байлгах, тэдгээрийн цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, шинжилгээний хариу, гэрийн шаахай (тавчиг), 4,5 ээлжийн амны хаалт (маск)-тай, 2 хувь эрүүл мэндийн үзлэгийн анкет, 3 хувь цээж зураг бүрдүүлж ирүүлэхийг багийн Засаг дарга нарт даалгасугай.

8. Цэрэг татлагад шаардлагатай шатахууныг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг нягтлан бодогч (Э.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

A red square stamp containing a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to be 'Н.Отгонцогт'. The stamp also contains some faint Mongolian text, likely identifying the official and their position.

Н.ОТГОНЦОГТ